

Япон улсын Гадаад хэргийн яамнаас хэрэгжүүлж буй 2016 оны
Хөгжлийн Албан Ёсны Тусламж (ХАЁТ)-ийн үнэлгээ

Байгаль орчны бохирдлын талаар
Япон улсаас авч хэрэгжүүлж буй
хамтын ажиллагааны үнэлгээ

2017 оны 3 дугаар сар

Олон улсын хөгжлийн төв ХК

Өмнөх үг

Олон улсын хөгжлийн төв ХК нь 2016 онд Япон улсын Гадаад хэргийн яамнаас хэрэгжүүлж буй 2016 оны ХАЁТ-ийн үнэлгээний нэг хэсэг болох “Байгаль орчны бохирдлын талаар Япон улсаас авч хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны үнэлгээ”-г хийж гүйцэтгэн, энэхүү тайланд судалгааны үр дүнг нэгтгэлээ.

Япон улсын Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) нь 1954 оноос хэрэгжиж эхлэснээс хойш хөгжиж буй орнуудын хөгжил буюу цагийн аясаар өөрчлөгдөх олон улсын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажилд хувь нэмэр оруулж, өнөө үед дотооддоо болон олон улсын хэмжээнд илүү чанартай, үр өгөөжтэй, үр дүнтэй тусламж хэрэгжүүлэх найдлага тавигдах болсон билээ. Гадаад хэргийн яам нь ХАЁТ-ийн менежментийг сайжруулах, ард иргэдэд ил тод, хариуцлагатай байх гэсэн 2 үндсэн зорилгын хүрээнд бодлогын түвшний ХАЁТ-ийн үнэлгээг жил бүр хэрэгжүүлдэг бөгөөд түүний ил тод буюу бодит байдлыг хангах зүгээс гадны байгууллагаар хөндлөнгийн үнэлгээг хэрэгжүүлж байгаа юм.

Энэхүү үнэлгээний судалгааг Япон улсаас авч хэрэгжүүлж буй байгаль орчны бохирдлын эсрэг хэрэгжүүлж буй бодлого болон хамтын ажиллагааг авч хэлэлцэн, Японы Засгийн газрын цаашдын байгаль орчны чиглэлд авч хэлэлцүүлэх хамтын ажиллагааны чиглэлд санал дэвшүүлэх, үр дүнтэй, үр өгөөжтэй хэрэгжилтийн сургамж болгох үүднээс зөвлөмж гарган, түүнчлэн үнэлгээний дүнг өргөн хүрээнд олон нийтэд таниулах замаар ард иргэдийн өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн.

Тус судалгааг хэрэгжүүлэхэд Сэйкэй их сургуулийн хүндэт профессор Хироно Рёкичиг үнэлгээний ахлах мэргэжилтэнээр үнэлгээний ажлыг нийтэд нь удирдуулан, түүнчлэн Аояма гакүэн их сургуулийн эдийн засгийн факультетийн профессор Мацүмото Шигэрүг зөвлөхөөр ажиллуулан судалгааны хэрэгжилтээс тайлан боловсруулах хүртэлх хугацаанд үнэтэй зөвлөгөө аван, хамтран ажилласан. Түүнчлэн орон нутгийн болон газар дээрх судалгаанд Гадаад хэргийн яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), ХАЁТ-ийн ажлын хэсэг холбогдох албаны хүмүүс, Монгол улсын Засгийн газар, хандивлагч, ТББ, орон нутгийн удирдлагын байгууллага зэрэг холбогдох олон байгууллага дэмжлэг тусалцаа үзүүлсэн, энэ дашрамд талархал илэрхийлье.

Эцэст нь, энэхүү тайланд тусгагдсан үзэл бодол нь тус судалгааны багийн баримтлал бөгөөд Япон улсын Засгийн газрын байр суурийг шууд илэрхийлэхгүй гэдгийг энд тэмдэглэе.

2017 оны 3 дугаар сар

Олон улсын хөгжлийн төв ХК

**Байгаль орчны бохирдлын талаар
Япон улсаас авч хэрэгжүүлж буй
хамтын ажиллагааны үнэлгээ
(Үнэлгээний хураангуй)¹**

Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

- Багийн ахлах Хироно Рёкичи, Сэйжэй их сургуулийн хүндэт профессор
- Зөвлөх Мацүмото Шигэрү, Аоямагакүин их сургуулийн профессор
- Зөвлөх баг Олон улсын хөгжлийн төв (ХК)



Эх сурвалж: Япон улсын ГХЯ

Хэрэгжилтийн хугацаа: 2016 оны 6 сар - 2017 оны 2 сар

Судалгаа хийх улс: Монгол улс

Судалгааны үндэслэл, зорилго, объект

Байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ нь ХАЁТ-ийн дунд хугацааны бодлого (2005 оны 2 сар) зэрэг байгаль орчны салбарын ХАЁТ-ийн тэргүүлэх салбарын нэг юм. Энэхүү үнэлгээ нь байгаль орчны бохирдлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хөгжлийн үзэл баримтлал болон гадаад харилцааны өнцгөөс үнэлэн, түүний үр дүнгээс сургамж буюу зөвлөмж гарган, цаашдын байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны чиг хандлагыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд нэмэр болох, ард иргэдийн өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлэх зорилготой.

Үнэлгээний үр дүнг нэгтгэх

- Хөгжлийн өнцгөөс үнэлэх нь

(1) Бодлогын нийцтэй байдал

Байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны бодлого нь Япон улсын хувьд тэргүүлэх бодлоготой дээд зэргээр уялдаж байгаа. Түүнчлэн ихэнх хөгжиж буй улсуудад иргэдийн эрүүл мэнд болон эдийн засаг, нийгмийн олон төрлийн хөгжлийн хэрэгцээ шаардлагатай уягдах “тогтвортой хөгжил”-ийг зорилт болгосон өнөөгийн олон улсын чиг хандлага, олон улсын тулгамдаж буй асуудалтай нийцэж байна. Мөн байгаль орчны бохирдлын асуудлыг харьцангуй богино хугацаанд шийдвэрлэсэн Япон улсын байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ, бодлого дэлхий дахинд өндөр үнэлгээ авдаг төдийгүй энэ салбарын гадаад хамтын ажиллагаанд Япон улс олон тал дээр өндөр үнэлгээ авдаг зэргээс энэхүү хамтын ажиллагааны бодлогын үндэслэлтэй байдал өндөр хэмээн үзэж байна.

(2) Үр дүнгийн өгөөжтэй байдал

Хамтын ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн өгөөжтэй байдлын тухайд үнэлгээ хийх явцад DAC (Development Assistance Committee)-ын гишүүн орнууд дунд хамгийн өндөр гүйцэтгэлтэй (амласан хөрөнгийн хэмжээ) байгаагаас “ерөнхийдөө өндөр” гэж үнэлж болно. Хэрэгжүүлсэн төслийн хувьд зорилтот үр дүнд хүрсэн байгаа бөгөөд үүний дүнд байгаль орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээ сайжирсан. Энэхүү төслөөр авч хэрэгжсэн “хэрэгжүүлэх арга зам, аргачлал” аль аль нь бодитоор хэрэгжин, байгаль орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээг сайжруулах, бэхжүүлэх зорилтод үр нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. Иймд байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний үр өгөөжтэй байдал нь “өндөр” юм. Хөгжиж буй орнуудын байгаль орчны бохирдлын тухайд тодорхой хэмжээнд үр дүн харагдаж байгаа хэдий ч үр дүнгийн хэмжээ харилцан адилгүй, хөгжлийн түвшин доогуур улс орнуудад ялангуяа байгаль орчны бохирдлын нөхцөл байдал төдийлөн сайн бус бүс нутаг, улс орон, салбар олон байна. Гэхдээ байгаль орчны бохирдлыг бууруулахад гадны нөлөөлөл их байдаг төдийгүй гадны нөхцөл, нөлөөлөлд тэр бүр арга хэмжээ авах бололцоо хязгаарлагдмал байдаг. Гадны нөлөөллийг тооцохгүйгээр зөвхөн байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээг авч үзэхэд тодорхой хэмжээний үр дүн гарсан гэж үзэж байна. Иймд байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний үр ашигтай байдлыг “тодорхой хэмжээнд өндөр” гэж үнэлж байна. Эдгээрээс энэхүү байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны үр дүнгийн өгөөжтэй байдлыг “ерөнхийдөө өндөр” хэмээн дүгнэж байна.

¹ “Байгаль орчны бохирдлын талаар Япон улсаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үнэлгээ” тайлангийн энэ эмхтгэл нь дэлхий даяар хэрэгжүүлж буй Япон улсын байгаль орчны эсрэг арга хэмжээний үнэлгээг нэгтгэсэн. Иймд, “Үнэлгээний хураангуй”-д Байгаль орчны эсрэг Япон улсаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үнэлгээ тайлангийн үр дүнг хураангуйлан тусгасан байгаа. 2-р бүлгээс хойш, энэхүү тайлангийн 3 р бүлэгт “Монгол улсын жишиг судалгаа”-г нэгтгэн тоймлосон.

(3) Үйл явцын зохистой байдал

Тус байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны үйл ажиллагааны хувьд өргөн хүрээнд холбогдох хүмүүсийг оролцуулсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, олон талын байр суурь, санал бодлыг тусгасан бодлого болсон тул үйл авцын зохистой байдлыг ерөнхийдөө өндөр хэмээн үнэлж байна. Бодлого хэрэгжилтийн үйл авцын бодлогын үндсэн чиг хандлагын хувьд идэвхтэй хэрэгжсэн гэж дүгнэж болох ба “хэрэгжилтийн механизм” буюу “холбогдох байгууллага, бусад хандивлагчидтай хамтрах, зохицуулалт хийх” зэрэг ажлууд нэлээд оновчтой хэрэгжсэн хэдий ч бодлогын түвшний “хяналт шинжилгээ, үнэлгээ болон түүний эргэн мэдээлэл” буюу “дүгнэх” ажил хийгдээгүй, нийтэд нь авч үзэхэд зохистой байдал нь “тодорхой хэмжээнд өндөр” гэсэн үнэлгээ өгч байна. Эдгээрээс энэхүү байгаль орчны хамтын ажиллагааны үйл аявцын зохистой байдал нь “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж болно.

• Гадаад харилцааны өнцгөөс үнэлэх нь

Гадаад харилцааны ач холбогдлын тухайд хөгжиж буй орнуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх нь Япон улсын харьцангуй давуу талыг ашиглан улсаа сурталчлах боломжтой болох зэрэг хангалттай ач холбогдолтой. Гадаад харилцааны үр нөлөөний тухайд хөгжиж буй улстай 2 улс хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрш зэргэлдээ орнуудтай хамтын ажиллагаа бэхжүүлэх (Зүүн хойд Азийн тогтвортой байдал), эдийн засгийн хориг арга хэмжээ тавигдсан улстай хоёр улс хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнээс гадна Мизүмата конвенцэд нэгдэх санаачлагаар дамжуулан олон улсын хэмжээнд нийгэм рүү чиглэсэн сурталчилгааны үйл ажиллагаанд хувь нэмэр оруулсан. Иймд “гадаад харилцааны ач холбогдол өндөр буюу үр нөлөөтэй байна” хэмээн үнэлэлт өгч байна.

Зөвлөмж

1. Бусад салбарын ХАЁТ-ийг хамруулсан өргөн хүрээнд дэх зөвлөмж

(1) Байгаль орчны хамгаалал, арга хэмжээний гол чиг хандлага бий болгоход чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа

2. Байгаль орчны салбарын ХАЁТ-ийн зөвлөмж

Бодлого боловсруулалтад холбогдох зөвлөмж

(2) Япон улсын байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны бодлогын бичиг баримт боловсруулах

Бодлогын үндсэн чиг хандлагатай холбогдох зөвлөмж

(3) Байгаль орчны хамгаалал, байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний гол чиг хандлага бий болгоход чиглэсэн дэмжлэг үзүүлэх

(3-1)Бодит, зөв мэдээлэл цуглуулах, анализ, мониторинг, үнэлгээ хийх хүний нөөц бэлдэхэд дэмжлэг үзүүлэх

(3-2) Үр дүнтэй байгаль орчны бодлого хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг дэмжих

(3-3)Олон төрлийн зорилтот бүлгийн байгаль орчны хамгаалалд оролцох оролцооны механизм бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

(3-4)Байгаль орчны хамгаалалтай холбогдох бодлого боловсруулах, хуучлах, тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэг

(3-5)Иргэдийн байгаль орчны ухамсрыг дээшлүүлэхэд үзүүлэх дэмжлэг

Бодлого хэрэгжилтэд холбогдох зөвлөмж

(4) Японы байгаль орчны эсрэг хамтын ажиллагаатай холбогдох мэдээллийн сүлжээг бэхжүүлэх

(5) Байгаль орчны бохирдолтой тэмцэх (эрхэм зорилго) бодлого хэрэгжилтэд чиглэсэн арга хэмжээ

Гадаад харилцааны талаас өгөх зөвлөмж

(6) Олон улсын ерөнхий хүрээ болон олон улсын хэмжээний уулзалт, зөвлөгөөн дэх манлайлах, гадаад харилцааны үр дүнг өргөжүүлэх



Улаанбаатар хотыг бүрхэх агаарын бохирдол



Улаанбаатар хотын захын гэр хороолол

Гарчиг

1-р бүлэг Үнэлгээний хэрэгжилтийн чиг хандлага	1
1-1 Үнэлгээний үндэслэл, зорилго.....	1
1-2 Үнэлгээний субъект	1
1-3 Үнэлгээ хэрэгжүүлэх аргачлал	3
1-3-1 Үнэлгээнд дүн шинжилгээ хийх аргачлал, хамрах хүрээ	3
1-3-2 Үнэлгээ хэрэгжүүлэх дараалал	3
2-р бүлэг Монгол улсын жишээ судалгаа	3
2-1 Жишээ судалгааны агуулга.....	3
2-2 Монгол улсын байгаль орчны бохирдол, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар.....	4
2-2-1 Агаарын бохирдол.....	4
2-2-2 Усны бохирдлын асуудал.....	4
2-2-3 Хатуу хог хаягдлын асуудал	5
2-2-4 Уул уурхайн хөгжлийн асуудал.....	5
2-3 Монгол улсад Япон улсаас авч хэрэгжүүлсэн байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ.....	6
2-4 Япон улсаас Монгол улсад хэрэгжүүлж буй байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний хөгжлийн болон гадаад харилцааны хийсэн талаас үнэлгээ	6
2-4-1 Бодлогын нийцтэй байдал.....	6
2-4-2 Үр дүнгийн өгөөжтэй байдал	9
2-4-3 Үйл явцын зохистой байдал	13
2-4-4 Гадаад бодлогын өнцгөөс үнэлэх нь	14
3-р бүлэг. Монгол улсын байгаль орчны бохирдлыг бууруулах бодлогыг сайжруулах талаарх зөвлөмж	15
3-1-1 Бусад салбарын ХАЁТ-ийг хамруулсан өргөн хүрээний зөвлөмж.....	15
3-1-2 Байгаль орчны салбар дахь ХАЁТ-ийн талаарх санал	18

1-р бүлэг Үнэлгээний хэрэгжилтийн чиг хандлага

1-1 Үнэлгээний үндэслэл, зорилго

Байгаль орчны асуудал нь Япон улсын олон улсын хамтын ажиллагааны тэргүүлэх асуудал бөгөөд үүн дотроо байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ нь байгаль орчны ХАЁТ-ийн тэргүүлэх салбар юм. Япон улсын хувьд байгаль орчны бохирдлын эсрэг авч хэрэгжүүлсэн бодлогын хувьд туршлага, мэдлэг болон технологи ихээр хуримтлуулсан байдаг тул хөгжиж буй орнуудын орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд ашиглан олон төрлийн дэмжлэг, хамтын ажиллагаа хэрэгжүүлж байна. Энэхүү үнэлгээнд холбогдох арга хэмжээ, тусламжийн талаар хөгжлийн үзэл баримтлал буюу гадаад харилцааны талаас нэгдсэн баталгаажуулалт хийн, түүний үр дүнгээс сургамж болон зөвлөмж гарган, цаашдын байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нэмэр болох, ард иргэдийн өмнө хүлээсэн ил тод байдлыг хангах хариуцлагаа биелүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн.

1-2 Үнэлгээний субъект

Үнэлгээний гол субъект нь байгаль орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээ байгаа хэдий ч Япон улсын байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагаа нь өнөөг хүртэл байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны бодлого гэсэн бодлогын бичиг баримт болж нэгтгэгдэж байгаагүй. Иймд тодорхой бодлогын бичиг баримт болгон ХАЁТ-ийн дунд хугацааны бодлого (2015 оны 2 сар), тогтвортой хөгжилд чиглэсэн байгаль орчныг хамгаалах санаачлага (EcolSD), салбарын чиг хандлага зэрэгт тулгуурлан энэхүү бодлогын зорилтыг бүдүүвч зургаар цэгцлэн харууллаа. Гэхдээ зорилтын бүдүүвч зургийн хувьд дээр дурдсан 3 бодлогын бичиг баримтын байгаль орчны холбогдох бодлогын бичиг баримтад хамаарах субъект, түвшин харилцан адилгүй байгаагаас 1) байгаль орчин (чиг хандлага, арга зам) → 2) байгаль орчны бохирдол (арга хэмжээ) → 3) агаарын бохирдол зэрэг тэргүүлэх 3 салбар (арга хэмжээ, стратеги зорилт) зэргийг дараах байдлаар цэгцэллээ.


Үнэлгээнд хамрагдах хугацаа, салбар, бүс нутаг, анализ шинжилгээний хүрээг дараах байдлаар тодорхойлов.

(1) Хамрагдах хугацаа: ХАЁТ-ийн дунд хугацааны бодлого боловсруулагдсан 2015 оноос хойш

(2) Хамрагдах салбар: Байгаль орчны бохирдол (Агаарын бохирдлын эсрэг арга хэмжээ, усны чанарын бохирдлын эсрэг арга хэмжээ, хатуу хог хаягдлын боловсруулалт гэсэн 3 салбарт гол ахнаарлаа хандуулна)

(3) Хамрагдах бүс нутаг: Нийт дэлхий дахин (жишээ болгон Монгол улс)

(4) Үнэлгээнд хамрагдах: Гадаад харилцааны яам/ ЖАЙКА, Байгаль орчны яам зэрэг олон улсын хамтын ажиллагаа болон хоёр улсын хамтын ажиллагааны чиг хандлага, хөтөлбөр, төсөл, бусад үйл ажиллагаа



Жич : Цөвхэр нь үнэлгээний баг нэмсэн асуудал
 Шар нь бичиг баримтын нэр

Эх сурвалж: ХАЕТийн дунд хугацааны бодлого (2005 оны 2 сар), Тогтвортой хөгжилд чилэсэн байгаль орчны хамгаалах санаачлага (EcoISD), салбарын хамтын ажиллагааны чиг хандлагад тулгуурлан Үнэлгээний баг боловсруулав.

Зураг 1-2-1 Японы байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны зорилтын б?д?вч зураг

Байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ

Байгаль орчны нэгдсэн арга хэмжээ

1-3 Үнэлгээ хэрэгжүүлэх аргачлал

1-3-1 Үнэлгээнд дүн шинжилгээ хийх аргачлал, хамрах хүрээ

Үнэлгээнд дүн шинжилгээ хийх аргачлал нь (1) Үнэлгээ явуулах чиглэл тогтоох, (2) Монгол улсын жишээ судалгаа, (3) Үнэлгээний үр дүнг нэгтгэх юм. Үнэлгээний үр дүнг нэгтгэсэн тайланд, дээрх (1)-(2) тулгуурлан Гадаад харилцааны яам ХАЁТ-ийн үнэлгээ хийх удирдамж (10 дахь хэвлэл) (2016 оны 6 сар) дагуу хөгжлийн үзэл баримтлал талаас хийх үнэлгээ (бодлогын нийцтэй байдал, үр дүнгийн өгөөжтэй байдал, үйл явцын зохистой байдал) болон гадаад харилцааны байр сууринаас үнэлгээг хэрэгжүүлсэн. Хөгжил талаас нь үнэлэх үнэлгээний 3 шалгуур үзүүлэлтээр дараах байдлаар дүгнэсэн. Түүнчлэн тэдгээр үр дүнд тулгуурлан зөвлөмж боловсруулсан.

Хүснэгт 1-3-1 Хөгжил талаас үнэлэх үнэлгээний түвшин, нөхцөл

Үнэлгээний шалгуур үзүүлэлт	Үнэлгээний түвшин	Үнэлгээний нөхцөл
Бодлогын нийцтэй байдал	Өндөр Ерөнхийдөө өндөр Тодорхой хэмжээнд өндөр Өндөр бус	Бараг ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авсан Бараг ихэнх үзүүлэлт дээр ерөнхийдөө өндөр үнэлгээ авсан Ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авсан Ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авч чадаагүй
Үр дүнгийн өгөөжтэй байдал	Өндөр Ерөнхийдөө өндөр Тодорхой хэмжээнд өндөр Өндөр бус	Бараг ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авсан Бараг ихэнх үзүүлэлт дээр ерөнхийдөө өндөр үнэлгээ авсан Ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авсан Ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авч чадаагүй
Үйл явцын зохистой байдал	Өндөр Ерөнхийдөө өндөр Тодорхой хэмжээнд өндөр Өндөр бус	Бараг ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авсан Бараг ихэнх үзүүлэлт дээр ерөнхийдөө өндөр үнэлгээ авсан Ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авсан Ихэнх үзүүлэлт дээр өндөр үнэлгээ авч чадаагүй

Эх сурвалж: Гадаад харилцааны яам ХАЁТ-ийн үнэлгээний удирдамжид (10 дахь хэвлэл) тулгуурлан боловсруулав.

1-3-2 Үнэлгээ хэрэгжүүлэх дараалал

Энэхүү үнэлгээг 2016 оны 7 сараас 2017 оны 2 сар хүртэлх хугацаанд (1) үнэлгээний хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, (2) Япон дахь судалгаа, (3) Монгол дахь судалгаа, (4) Япон дахь дүн шинжилгээ, тайлан боловсруулах гэсэн дарааллаар хэрэгжүүлсэн.

2 р бүлэг Монгол улсын жишээ судалгаа

2-1 Жишээ судалгааны агуулга

Япон улс нь Монгол улсын хувьд томоохон хандивлагч улсын нэг бөгөөд нийслэл Улаанбаатар хот агаарын бохирдол, хатуу хог хаягдлын менежмент зэрэг салбарт хамтын ажиллагааны арвин их туршлагатай, усны бохирдлын тухайд ч хамтран ажиллаж байсан тул Монгол улсыг жишээ болгон сонгон авсан. 2016 оны 10 сарын 12-ноос 21 хүртэл Монголд хийсэн судалгаагаар мэдээлэл цуглуулан хөгжлийн талаас хамтын ажиллагааны бодлогын нийцтэй байдал, үр дүнгийн өгөөж, үйл явцын зохистой байдлын талаар, гадаад харилцааны өнцгөөс гадаад харилцааны ач холбогдол, дам үр нөлөөллийн талаар үнэлэлт, дүгнэлт өгсөн.

2-2 Монгол улсын байгаль орчны бохирдол, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

2-2-1 Агаарын бохирдол

ДЭМБ-ын 2010 оны судалгаагаар Монгол улсын нийслэл Улаанбаатар хот дэлхийн агаарын бохирдолтой 10 хотод жагсаагдаж байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжилтийн дүнгээс² харахад жилийн туршид ДЭМБ-ын агаарын чанарын стандартыг хангаагүй. Ялангуяа өвлийн улиралд улам ноцтой болдог агаарын бохирдол хүүхэд болон хөгшид голдуу амьсгалын замын өвчлөлийн гол шалтгаан болоод байгаа нь тодорхой бөгөөд ард иргэд агаарын бохирдлын асуудалд эмзэг хандаж байна. Агаарын бохирдлын гол шалтгаан нь 1) Гэр хорооллын иргэдийн нүүрсний хэрэглээ, 2) Үйлдвэр, цахилгаан станцын нүүрсний хэрэглээ, 3) Арчилгаа, үйлчилгээ муу хийгдсэн автомашины өсөлт зэрэг болно.

Гэр хорооллын нүүрсний хэрэглээ нь хотжилт болон ядуурлаас хамааран өсөн нэмэгдэж байна. Хөдөө орон нутгаас ажлын байр хайн жил бүр олон зуун иргэд шилжин суурьшдаг, тэдгээр нь ихэнхдээ ядуу зүдүү амьдралтай, Улаанбаатар хотын захад гэр барин амьдардаг. Хүйтэн ширүүн өвлийн улиралд дулаалгаа хангахын тулд их хэмжээний нүүрс галлан, тэр нь агаарын бохирдол үүсэх гол шалтгаан болж байна. Түүнчлэн Улаанбаатар хотын нийтийн тээврийн сүлжээ төдийлөн сайн хөгжөөгүй, хотын төмөр зам, трамвай гэх мэт нийтийн тээврийн хэрэгсэл байхгүй тул суудлын автомашины хэрэглээ өндөр тул авто замын түгжрэл болон агаарын бохирдол үүсч байгаа юм. Мөн автомашины үзлэг, хяналтын тогтолцоо зохих хэмжээнд үйлчлэхгүй, ачааны машин болон автобус зэрэг дизель мотортой автомашины арчилгаа, үйлчилгээ сайтар хийгддэггүйн улмаас автомашинаас их хэмжээний агаар бохирдуулагч бодис ялгарч байна.

2-2-2 Усны бохирдлын асуудал

Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэр нь Туул голын урсгал уснаас гаралтай гүний ус байдаг³. Огцом өсөн тэлэх хотжилт төдийгүй төв цэвэр усны байгууламжийн элэгдэл, хуучралаас үүдэн төв цэвэрлэх байгууламжийн хүчин чадлаас хол давсан хэмжээний хаягдал ус урсан ирж, хангалттай хэмжээнд цэвэрлэгдэхгүйгээр Туул гол руу урсан орж байна. Үүний дүнд ДЭМБ-ын судалгаагаар Туул гол нь дэлхий дээрх хамгийн их бохирдолтой 7 голын 5-рт орж байна. Усны бохирдол үүсгэж буй гол шалтгаан нь 1) Уул уурхайн олборлолтоос үүдэх хүнд металлын бохирдол, 2) Арьс ширний үйлдвэрийн хаягдал усан дахь задардаг органик азот, аммиакын хийн бохирдол, 3) Өсөн нэмэгдэх гэр хорооллын хаягдал бохир ус юм.

² Улаанбаатар хот (2015) “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”

³ Сато Хироши (2015) “Монгол улс: Туул голын бохирдлын байдал - Улаанбаатар хотын Сонгины амралт Suwor aupaum орчимд -”, Proceedings of the Research Institute of Social Systems, Chuo Gakuin University 15(2), 1 - 12.

2-2-3 Хатуу хог хаягдлын асуудал

Улаанбаатар хотод бусад хөгжиж буй орнуудын адил хотжилтоос үүдсэн хог хаягдлын асуудал хурцадмал байна. Дэлхийн банкны судалгаанаас үзэхэд доогуур орлоготой орны хотуудад хатуу хог хаягдал боловсруулахад нийт төсвийн 20-50% орчмыг зарцуулдаг⁴ ба, Улаанбаатар хотод мөн адил хатуу хог хаягдлын асуудал их хэмжээний хөрөнгө зарцуулдаг. Улаанбаатар хотын төсөв хүндрэлтэй байдлаас авч үзэхэд хог хаягдлыг багасгах арга хэмжээ нь бодлогын түвшний асуудал гэж хэлж болно.

Ердийн хог хаягдлыг 1) Айл өрхүүд хогоо ангилан цуглуулж, дундын хог боловсруулах цэгт хүргүүлэн, 2) Дундын хог боловсруулах цэг дээр дахин ашиглагдах хогыг авч ангилан, хөнгөлөх, 3) үлдэгдэл хогийг булж, эцсийн боловсруулалт явуулах гэсэн дэс дарааллаар боловсруулна. Ийм шаталсан процессд 2) дахь шатны зардлыг бууруулан, дахин боловсруулах үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхийн тулд 1) дэхь шатны ард иргэдэд хог хаягдал боловсруулах хэрэгцээ, ач холбогдлын талаар ойлголт өгөн, хог хаягдлыг ангилан, дахин боловсруулахад дэмжлэг авах шаардлагатай. Гэвч Монголчуудын хувьд саяханаас хот суурин газарт амьдардаг болсон тул хог хаягдлын ангилах, дахин боловсруулах ач холбогдлыг сайтар ойлгоогүй байна. Иймд хог хаягдлыг ангилах, дахин боловсруулалтын ажил урагштай явагдаагүй. Түүнчлэн байгаль орчны бохирдлын эрсдлийг бууруулахын тулд, 3) дахь шатанд тохиромжтой аргаар булж боловсруулах хэрэгтэй бөгөөд одоогоор хог боловсруулах байгууламж дутагдалтай, байгаль орчны эрсдэл үүрсэн чигтээ хог хаягдал боловсруулж байна.

2-2-4 Уул уурхайн хөгжлийн асуудал

Монгол улсад нүүрс, зэс, уран болон газрын ховор элемент зэрэг 80 төрлийн ашигт малтмал, ойролцоогоор 6,000 гаруй уурхай байдаг⁵. Баялаг ашигт малтмалын нөөцтэй Монгол улсын хувьд уул уурхайн салбар хамгийн том үйлдвэрлэлийн салбар бөгөөд Монгол улсын Засгийн газар байгаль орчны хамгаалах тухай багц хууль батлан, уул уурхайн хөгжлийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон баталгааны мөнгө байрлуулах зэргээр хуульчлан, хөгжлийн төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахаар чармайлт гарган ажиллаж байна. Гэсэн хэдий ч уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн хүнд металлын бохирдлын бодит байдлын талаарх мэдээлэл хоцрогдмол байгаа нь сэтгэл түгшээж байна. Сүүлийн жилүүдэд алт олборлолт огцом өссөн төдийгүй, нэг хэсэг нь Нинжа гэгддэг хууль бусаар алт олборлодог. Нинжа нар алт угаах шатандаа мөнгөн ус ашиглан, үүнээс үүдэн гол мөрөн, худгийн ус хүнд металлын бохирдолд өртдөг нь тодорхой болсон⁶. Түүнчлэн

⁴ World Bank (2011) Urban solid waste management.

⁵ Ёшимото Макото (2011) “Монголын уул уурхайн хөгжлийн өнөөгийн байдлын тухай” Аж үйлдвэрийн судалгааны эмхэтгэл (38), 61-68.

⁶ Мурао Сатоши, Ё.Кавабэ, Сэра Коичиро, Сато Ёоко, Такахаши Чиеко, Б.Түмэнбаяр, У.Жамбалдорж (2011), “Монгол улсын хойд хэсгийн хүнд металлын бохирдол болон эрсдлийн менежмент - урьдчилсан тооцоолол - ”, NMCC хамтарсан судалгааны тайлангийн эмхэтгэл 18, 102—107. Нагата Хироаки, Цүкада Казүхиро, Ямамото Коүжи (2012) “Монгол улсын Бороо голын алтны уурхайн ойролцоох нутгийн хүнд

1989 онд Дорнодын уурхайн нэг хэсэгт ураны гүний олборлолт явагдаж эхэлсэн. Хөрөнгө санхүүгийн асуудлаас энэхүү уурхайн үйл ажиллагаа удалгүй зогссон хэдий ч, 1996 оноос хойших судалгаанаас Монгол улсад нийт 100 гаруй бичил уурхай байгаа нь тодорхой болсон⁷.

2-3 Монгол улсад Япон улсаас авч хэрэгжүүлсэн байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ

Тус үнэлгээний хамрагдах хугацаанд (2005 оноос 2016 он) Монгол улсад хэрэгжсэн Япон улсын байгаль орчны бохирдлын эсрэг авч хэрэгжүүлсэн хамтын ажиллагааны нийт 16 төсөл байна. Байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний тэргүүлэх 3 салбар болох агаарын бохирдол (4 төсөл), усны бохирдол (4 төсөл), хатуу хог хаягдлын менежмент (4 төсөл), бусад (4 төсөл) гэсэн ангиллаар хөгжлийн судалгаа, техникийн хамтын ажиллагаа, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, хувийн хэвшилтэй хамтарсан жижиг дунд үйлдвэрлэлийн гадаад дахь үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн засаг захиргаа хоорондын хамтын ажиллагааны Өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа, салбарын сургалт, Байгаль орчны яамны төсөл зэрэг олон төрлийн хамтын ажиллагааны хэлбэр, оролцогчдын дэмжлэг туслалцаатай хэрэгжиж ирсэн. Түүнчлэн Япон улсын Байгаль орчны яам болон Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам хооронд 2007 оноос хойш Япон, Монгол байгаль орчны бодлогын зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулдаг. Гол зорилго нь 2016 он хүртэл байгаль орчныг хамгаалах, сэргээхэд чиглэсэн харилцан хамтын ажиллагааг бэхжүүлэх, сайжруулах, хөгжүүлэх бөгөөд 2016 он хүртэл 10 удаа зохион байгуулагдаад байгаа билээ.

2-4 Япон улсаас Монгол улсад хэрэгжүүлж буй байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний хөгжлийн болон гадаад харилцааны хийсэн талаас үнэлгээ

2-4-1 Бодлогын нийцтэй байдал

Япон улсын байгаль орчны бохирдлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь Стратегийн түншлэлийн дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр (2013-2017) болон Монгол улсад үзүүлэх тусламжийн чиг хандлага зэрэг Япон улсын дээд түвшний бодлого буюу хөгжлийн бусад холбогдох бодлоготой нягт уялдсан, эдийн засгийн хүндрэлтэй байгаа өнөөгийн цаг нөхцөлд эдийн засгийг сэргээх асуудал нэн тэргүүнд байгаа хэдий ч Монгол улсын Засгийн газар болон Улаанбаатар хотын хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол улсын байгаль орчны холбогдох бодлого, Монгол улсын хөгжлийн хэрэгцээ, шаардлагатай уялдаа холбоо ерөнхийдөө өндөр байна. Түүнчлэн, Монгол улсад олон улсын чиг хандлагатай зэрэгцэх маягаар байгаль орчны бохирдлын эсрэг бодлого хэрэгжүүлж эхэлсэн үед Япон улсын байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагаа мөн хэрэгжиж эхэлсэн,

металлын бохирдлын талаарх судалгаа”, Abstracts of Annual Meeting of the Geochemical Society of Japan 59, 237.

⁷ Цүчия Харуаки(2008) “Монгол улсын ураны орд газар болон ашиглалтын өнөөгийн байдал (2008) Ашигт малтмалын тайлан, 48 - 57.

бодлого боловсруулах явцад бусад хандивлагч улсуудтай нягт хамтын ажиллагаатай явагдаж байснаас авч үзэхэд олон улсын чиг хандлага, олон улсын асуудалтай мөн уялдаа өндөр түвшинд байна. Агаарын бохирдол, хатуу хог хаягдлын менежментийн салбар нь Япон улсын харьцангуй давуу талыг ашиглах боломжтой салбар байгааг үнэлэгдэж байгаа, мөн бохирдлын асуудлыг шийдвэрлэж чадсан Японы орон нутгийн захиргааны бодит туршлага, сургамжаас суралцахын тулд орон нутгийн хамтын ажиллагаа, EcolSD үндсэн чиг хандлагад нийцүүлэх маягаар ЖАЙКА-ийн давуу талыг ашиглан төрийн албан хаагчдын хүний нөөцийн хөгжил, олон төрлийн тусламжийн хэлбэрийг хослуулсан багц хэлбэрийн хамтын ажиллагаа болон төслийн хэв маяг ашиглагдаж байгаа нь Япон улсын харьцангуй давуу талыг ашигласан аргачлал хэмээн хамтын ажиллагааны холбогдох хүмүүсээс өндрөөр үнэлэгдэж байгаа. Япон улс хамтын ажиллагаа явуулах үндэслэлтэй байдал маш өндөр хэмээн дүгнэж байна. Эдгээрээс бодлогын үндэслэлтэй байдлыг өндөр хэмээн дүгнэж байна.

(1) Япон улсын дээд түвшний бодлого, холбогдох бодлого төлөвлөлттэй уялдаатай байдал

Япон улсаас Монгол улсад авч хэрэгжүүлж буй байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ нь Япон, Монгол 2 улс хамтран боловсруулсан Стратеги түншлэлийн дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр (2013-2017) Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөрт (2012) тулгуурлан хэрэгжиж байна. Түүнчлэн нийгмийн дэд бүтцийг бэхжүүлэх, хөгжлийн бусад салбарын олон тооны хамтын ажиллагаанд байгаль орчны бохирдлыг хамгийн бага хэмжээнд хязгаарлахыг Японы ХАЁТ шаардлага тавьдаг. Стратеги түншлэлийн дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр буюу одоогийн Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөрт Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр хэмээн хөрөнгө болон техникийн хамтын ажиллагааны цогц тусламж үзүүлж буй бөгөөд дараагийн Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөрт эдгээр тусламжийг хөдөө орон нутагт дэлгэрүүлэн авч хэрэгжүүлэх чиглэлтэй байгаагаас Япон улсын Монгол улсад хэрэгжүүлсэн байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ нь Япон улсын дээд түвшний бодлого холбогдох бодлого төлөвлөлттэй бүрэн дүүрэн уялдаж байгаа бөгөөд уялдаа өндөр хэмээн үнэлгээ өгч байна.

(2) Монгол улсын хөгжлийн хэрэгцээ, шаардлагатай уялдаж буй эсэх

Өнөөгийн Монгол улсын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас эдийн засгийг сэргээх асуудал нэн тэргүүнд тавигдах шаардлагатай байгаа ч Монгол улсын Засгийн газраас баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (SDV2030), “Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулан батлуулсан “Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 2016-2020” зэрэг Монгол улсын хөгжлийн хэрэгцээ, шаардлагын ихэнхэд Япон улсын хамтын ажиллагаа нь “Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх” чиглэлээр “Хотын байгаль орчны менежментийг сайжруулах” хөтөлбөрт тусгагдсан

байгаль орчны бохирдлын эсрэг төслийг хэрэгжүүлж ирсэн. Цаашид улам хөдөө орон нутагт үйл ажиллагааг өргөжүүлэн байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааг үргэлжлүүлэх хэрэгцээг Монгол, Япон 2 улс аль аль нь ойлгож байгаа тул Монгол улсын хөгжлийн хэрэгцээ, шаардлагатай “ерөнхийдөө өндөр” уялдаатай байна.

(3) Олон улсын байдал, олон улсын асуудалтай нийцэж буй эсэх

2011 оны ДЭМБ (WHO) ын судалгаанаас үзэхэд “Улаанбаатар хотын агаарын бохирдол дэлхийд хамгийн муу үзүүлэлттэй” байна⁸. 2012 онд Монгол улс Ази Номхон далайн цэвэр агаарын түншлэлд (APCAR) нэгдэн орсон. Түүнчлэн Япон улсын Засгийн газар, ТББ-тай санаачлагаар хамтран батлуулсан “НҮБ-ын тогтвортой хөгжилд чиглэсэн боловсролын 10 жил (UNDESD, 2015-14)” тулгуурлан, Монгол улсын байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ, биологийн олон төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээний нэг хэсэг болгон бага, дунд, ахлах сургууль, их, дээд сургууль зэрэг боловсролын байгууллага болон хэд хэдэн орон нутгийн засаг захиргаа, албан байгууллага дээр ESD болон экологийн боловсрол олгох үйл ажиллагаа эхлүүлэн, ард иргэдийн байгаль орчны талаарх ухамсар дээшилж буй цаг үе тохиогоод байна. Иймэрхүү байдлаар олон улсын хэмжээнд Монгол улсын агаарын бохирдлын асуудалд анхаарал хандуулан, Монгол улс олон улсын чиг хандлагыг дагах маягаар байгаль орчны бохирдлын эрсэг арга хэмжээ авах болсон цаг үед Япон улсаас байгаль орчны бохирдлын эсрэг, тэр дундаа агаарын бохирдлын эсрэг арга хэмжээнд хамтын ажиллагаа хэрэгжүүлсэн. Эдгээрээс, олон улсын чиг хандлага, нэн тэргүүний асуудалтай уялдах байдлын хувьд “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж болно.

(4) Япон улсаас хамтын ажиллагаа үзүүлж буй нь тохиромжтой эсэх

Агаарын бохирдол, хатуу хог хаягдлын менежментийн асуудал гэсэн Япон улс харьцангуй давуу талтай салбарын хувьд, агаарын бохирдлын хяналт шинжилгээний чадавхийг дээшлүүлэх зэрэг хүний нөөцийн хөгжил, хог хаягдлын менежментийн салбарт хүний нөөцийн хөгжлөөс гадна бусад олон төрлийн хамтын ажиллагааны хэлбэрийг оролцуулсан багц тусламж буюу технологи дамжуулах, хог ангилах зэрэг ард иргэдийн байгаль орчны ухамсарыг дээшлүүлэх, сурталчилгаа явуулах зэрэг аргачлалыг ашиглаж байна. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд Япон улсын орон нутгийн мэдлэг, туршлага дээр үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ Монгол улсын талаас өндрөөр үнэлэгдэж байна. Холбогдох хүмүүсээс Япон улс хүний нөөцийн хөгжилд өндөр туршлагатай гэдэг ойлголттой бөгөөд энэхүү давуу талаа ашиглахын тулд Япон улс цаашид байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагаанд хүний нөөцийн хөгжилд үзүүлэх дэмжлэг, тусламжаа үргэлжлүүлэх нь “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж байна. Харах өнцгөө өөрчлөн Япон улсын хувийн хэвшлийн үйл ажиллагааг авч үзэхэд, хувийн хэвшлийн Монгол улсад оруулж буй хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор зохион байгуулагддаг семинарт (“Invest Mongolia” зэрэг) байгаль орчны бохирдлын эсрэг салбар тэргүүлэх маягаар авч хэлэлцэгдэх нь олонтаа

⁸ http://cgi4.nhk.or.jp/eeco-channel/jp/movie/play.cgi?did=D0013773028_00000

байсан нь Япон улсаас авч хэрэгжүүлж буй байгаль орчны эсрэг арга хэмжээ нь Японы хувийн хэвшлийн хувьд шинэ бизнесийн боломж болох магадлалтай гэж үзэж байна. Хоёр орны хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаас үзсэн ч Япон улсаас авч хэрэгжүүлж буй Монгол улсын байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээг үргэлжүүлэх үндэслэл нь “маш өндөр” гэж дүгнэж байна.

2-4-2 Үр дүнгийн өгөөжтэй байдал

Японы хэрэгжүүлж ирсэн ХАЁТ нь Монгол Улс болон Улаанбаатар хотын суурь төлөвлөгөөн дэх бодлогын хэрэгжилттэй яв цав зохицож, энэ чигээр орживол улам бүр муудах төлөвтэй буй байгаль орчны бохирдлыг бууруулахад үүрэг гүйцэтгэж байгаа нь байгаль орчны хамтын ажиллагааны өгөөжтэй байдал, тэргүүлэх салбарт үзүүлэх өгөөжтэй байдлыг “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж байна. Нөгөөтэйгүүр, байгаль орчны бохирдлын эсрэг авч хэрэгжүүлсэн хамтын ажиллагааны нэгдсэн үр өгөөж нь Японы ЗГ-ын дэмжлэг тусламж нь монголын байгаль орчны менежментийн чадавхийг дээшлүүлэхэд тодорхой хэмжээнд хувь нэмэр болж байгаа гэж ойлгогдож байгаа боловч байгаль орчны бохирдлыг бууруулах бэлтгэл болгон зохион байгуулалт, чадавхи бүрдүүлэлт гэх мэт суурь баазыг бэхжүүлэх шатанд буй. Байгаль орчны бохирдол буурсан эсэх нь цаашдын Монгол Улсын ЗГ хандивлагч орнуудын хамт үргэлжлүүлэн тэргүүлэх чанартай асуудлыг шийдвэрлэн ажиллах шаардлагатай боловч өнөөг хүртэлх шатанд гаргасан үр дүнгийн өгөөж нь “тодорхой хэмжээнд өндөр” гэж үнэлэгдэж байна.

(1) Хамтын ажиллагааны өгөөжтэй байдал

Япон нь Монголын байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний тал дээр хамтран ажиллахдаа бусад хандивлагчтай харьцуулахад тасралтгүй, олон салбарт, монгол талын хэрэгцээ шаардлагын дагуу бөгөөд төслийн тоо цөөн боловч агаарын болон байгаль орчны бохирдол их, онцгой байдалтай байгаа Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа төвлөрүүлэн хэрэгжүүлж ирсэн билээ. Мөн тусламжийн хэмжээ бусад хандивлагчидтай харьцуулахад онцгой их биш боловч Монгол талын хэрэгцээ шаардлагад яв цав нийцсэн гэж тооцогддог. Олон янзын арга хэлбэрээр хэрэгжүүлэхдээ Японы орон нутгийн засаг захиргааны байгууллага болон хувийн хэвшлийнхэнийг ч оролцуулдаг. Энэ салбар дах хоёр орны хамтын ажиллагаа нь монголд илүү эрэлттэй агаарын бохирдлын эсрэг голчлон чиглэхийн зэрэгцээ Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банк гэх мэт олон улсын байгууллагын тусламж дэмжлэгээр дамжуулан ариутгах байгууламж, хог хаягдлыг дахин боловсруулах, хөрсний бохирдол зэрэг тулгамдсан асуудлууд, Улаанбаатар хотын гэр хороолол, хөдөө орон нутгийн ядуурлыг бууруулах зэрэг асуудлыг цогцоор нь авч үзэхдээ байгаль орчны арга хэмжээг нэг элемент болгосон төслийн хэрэгжилтэд ч мөн оролцдог юм. Үүнээс үзэхэд хамтын ажиллагааны өгөөжтэй байдлыг “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж байна.

(2) Тэргүүлэх салбарт үзүүлэх өгөөжтэй байдал

Байгаль орчны бохирдлын эсрэг Японоос авч хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны үр дүн, шийдвэрлэвэл зохих асуудлыг магадлан үзээд ерөнхийдөө үргэлжлүүлэн тусалж дэмжих шаардлагатай, гэхдээ тэргүүлэх салбарт хэрэгжүүлсэн хамтын ажиллагааны үр өгөөжийг “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж байна.

Тэргүүлэх 3 салбарт гарсан үр дүнгийн тухайд агаарын бохирдлын болон хог хаягдлын менежментийн салбарын төслүүд нь “Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн арга хэмжээг үр бүтээлтэйгээр багцлан, хослуульж ерөнхийдөө зорьсон үр дүндээ хүрсэн гэж үзэж болно. Агаарын бохирдлын салбарын хувьд, мониторингийн чадавхийг дээшлүүлэх хамтын ажиллагааны хүрээнд төслүүдийг хэрэгжүүлснээр бохирдуулагч эх үүсвэрийг тогтоох болон мониторинг хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой болсон. Хог хаягдлын менежментийн салбарын тухайд Японы хамтын ажиллагаа нь, Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зэрэг бодлогын болон төлөвлөх түвшингээс нь оролцож ирсэн бөгөөд буцалтгүй тусламжийн хүрээнд хог хаягдлын цэгийг барьж байгуулан, техникийн хамтын ажиллагааны хүрээнд хог хаягдлын менежментийг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэх замаар нэгэн багц болгон дэмжлэг үзүүлсэн нь хог хаягдлыг цуглуулах, боловсруулах чадавхийг дээшлүүлж, хог хаягдлыг булаах эрүүл ахуйн шаардлага хангасан арга хэлбэрийг нэвтрүүлэх, хог хаягдлын цэгийн байнгын үйл ажиллагааг хангахуйц хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг бодит үр дүн гаргасан юм.

Тэргүүлэх 3 салбарын хувьд, агаарын бохирдлын чиглэлээр монголын тал цаашид тоо баримтуудад өөрснөө бие даан дүн шинжилгээ хийдэг болох, хөдөө орон нутагт ч мониторинг хийх боломжтой болох зэрэг шийдвэрлэх асуудлууд үлдэж байна. Монголын агаарын бохирдлын асуудал нь ядууралтай холбоотой учраас бодит үр дүн гаргахын тулд нэлээн цаг хугацаа шаардлагатай. Хог хаягдлын менежментийн тухайд хог хаях, ялгах зэрэгтэй холбоотой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй байна. Монголын ГХЯ болон байгаль орчны чиглэлийн ТББ зэрэг төр болон хувийн хэвшлийнхнээс хог хаягдлын менежментийн салбарт японоос үзүүлж буй хамтын ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхийн тулд иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх нь чухал болох талаар дурьддаг. Усны бохирдлын тухайд, судалгааны явцад бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулах, гэр хорооллын усны чанар, хөрсний асуудал гэх мэт хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлын талаар тодорхой болсон ч бодитоор тусламж дэмжлэг үзүүлэх нь дараагийн шатны асуудал бөгөөд цаашид монгол талын хэрэгцээ шаардлагын дагуу бодит үр дүн гаргах хэрэгтэй. Мөн ерөнхийдөө нийгмийн эмзэг бүлгийг хамарсан, иргэдийн экологийн боловсролыг илүү түлхүү анхаарсан дэмжлэгийг хэрэгжүүлэх шаардлагатай.

(3) Монголын байгаль орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн хамтын ажиллагааны өгөөжтэй байдал

Японы байгаль орчны бохирдлыг бууруулах хамтын ажиллагааны бодлогод “байгаль орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг бэхжүүлэх, сайжруулах” зорилтыг 5 салбар тус бүрээр тодорхойлсон байдаг. Монголын эдгээр 5 салбарын зорилтыг хангахад чиглэсэн зохих хэмжээний үр дүн, шийдвэрлэвэл зохих асуудал тодорхой харагдаж буй боловч байгаль орчны бохирдлын өнөөгийн байдал ямар нэг сайжралгүй байна.

Монгол улс эдийн засгийн хямралын хажуугаар нийслэл рүү чиглэсэн хүн амын хэт төвлөрөлийн улмаас байгаль орчин улам бохирдож байгаагаас хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, сахиулах тогтолцоо, механизмыг бий болгох, үүнд чиглэсэн төр засгийн байгууллагууд хоорондын болон Засгийн газар, хот хоорондын уялдаа холбоотой хамтын ажиллагаа, бохирдуулагч эх үүсвэрт тавих хяналтыг бэхжүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх зэрэг бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг цаашид ч үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх шаардлага ургаж гарч байна. Байгаль орчны бохирдол буурч байгаа эсэх бодит үр дүн гарахад тодорхой хугацаа шаардлагатай. Олон янзын нөхцөл байдлын улмаас зорьж буй зорилгодоо хүрч үр дүн гаргаж чадаагүй ч байгаль орчныг бохирдуулахаас сэргийлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг авч, зохих ёсоор хэрэгжүүлж байгаа гэж үзэж байгаа тул Монголын байгаль орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн хамтын ажиллагааны нэгдсэн үр өгөөжийг “тодорхой хэмжээнд өндөр” гэж дүгнэж байна.

Салбар тус бүрээр дэвшүүлсэн зорилтыг хангасан байдал

“Зорилт 1: Төр засаг, хувийн хэвшил, иргэд болон их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага хамтран ажилласнаар байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлнэ” – агаарын бохирдлын салбарт тодорхой хэмжээний дэвшил гарч, суурь нь бүрдэх шатанд байгаа гэж үзэж болох боловч тоо баримтад дүн шинжилгээ хийх чадавхи, хөдөө орон нутагт агаарын бохирдлын тоо баримтад мониторинг хийх тал дээр асуудалтай бөгөөд усны бохирдлын салбарын тухайд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй байна. “Зорилт 2: Орон зайн хэмжээнд зохицсон агаарын чанарын менежментийг сайжруулах” – агаарын бохирдлын нөхцөл байдлыг магадлаж тодорхойлох боломжтой болсон боловч бохирдуулагч суурин болон хөдөлгөөнт эх үүсвэртэй тэмцэх зэрэг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд цаашид ч японы зүгээс дэмжиж ажиллах шаардлагатай болов уу. “Зорилт 3: Нутгийн онцлогт тохирсон усны чанарын менежментийг сайжруулах” – Японы зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хязгаарлагдмал, бодит дэмжлэг үзүүлэх нь дараагийн шатны үйл ажиллагаа бөгөөд энэ удаагийн үнэлгээний судалгааны хүрээнд ч усны чанартай холбоотой тоо, баримт олдоц бэрх байсанчлан усны чанартай холбоо бүхий хэмжилт, үзлэг, дүн шинжилгээ, мониторинг үнэлгээний чадавхийг сайжруулах шаардлагатай. “Зорилт 4: Хог хаягдлын менежментийн чадавхийг сайжруулах” – хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааны болон хог хаягдлын менежментийн чадавхи тогтвортой сайжирч ирсний нөгөөтэйгүүр

хог хаягдлын менежменттэй холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэдийн ухамсар, ойлголтыг дээшлүүлэх шаардлагатай байна. “Зорилт 5: Хог хаягдлын менежментийн технологийг сайжруулах” – Улаанбаатар хотын хог хаягдлыг боловсруулах чадавхи сайжирсан боловч хог хаягдлын хэмжээ өөрчлөгдөөгүй. Хог хаягдлыг менежментийн процессийг холбогдох талууд, иргэдэд сайтар ойлгуулж, технологийг сайжруулах шаардлагатай.

Байгаль орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд гарсан ахиц

Агаарын бохирдлын салбарт дорвитой ахиц гаралгүй, монголын байгаль орчны шалгуур үзүүлэлтэд хүрэхгүй удаж байгаа бөгөөд Улаанбаатар хот 2016 онд агаарын бохирдлоороо дэлхийд 5-д жагссан байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлын түвшингийн хувьд PM10 2012 оноос хойш, PM2.5 2010 оноос хойш буурах хандлагатай байгаа боловч шалгуур үзүүлэлт болох $50\mu\text{g}/\text{m}^3$ ⁹ –г хол давсан хэвээр байна. 2000 оноос хойш хүн амын хэт төвлөрөлөөс шалтгаалан хүхэрлэг хий (SO_2), автомашины тоо нэмэгдсэнээс шалтгаалан азотын давхар исэл (NO_2) улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 2014 онд бага зэрэг буурсан ч PM тоосонцрын хэмжээний адилар Улаанбаатар хотын байгаль орчны шалгуур үзүүлэлтээс ихээхэн хэтэрчихээд байна¹⁰.

Усны бохирдлын хувьд ч ямар нэг сайжрал гараагүй хэвээр байна. Улаанбаатар хотын бохир усны шугамд зөвхөн ахуйн хэрэглээний бохир усаар зогсохгүй үйлдвэрийн хаягдал усыг мөн хаядаг бөгөөд энэ нь Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн хүчин чадлаас хэт давсан ачааллыг бий болгож байна¹¹. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанд Туул гол дэлхийн хамгийн бохир 7 голын 5-д жагсаж байгаа талаар дурьдсан байна. Азийн хөгжлийн банкнаас Ази, Номхон далайн орнуудын усны аюулгүй байдлыг 5 зэрэглэлээр эрэмбэлэхэд Монгол Улс усан хангамж, хаягдал ус цэвэрлэх хүчин чадлаар 1 буюу хамгийн доод зэрэглэл, бохир усны дэд бүтцээр 3-р зэрэглэлд оржээ¹².

Хог хаягдлын менежментийн салбарын тухайд, Улаанбаатар хотын хог хаягдал цуглуулах, боловсруулах чадавхи нэлээн сайжирч, хогийг тогтмол цуглуулдаг болж сайжрах хандлагатай байгаа боловч хог хаягдлыг хэмжээ өнгөрсөн 3 жилийн хугацаанд огт өөрчлөгдөөгүйгээр барахгүй, хог хаягдлыг огт ялгахгүй хэвээр байгаа. Улаанбаатар хотод хүртэл хатуу хог хаягдлыг боловсруулахдаа эх үүсвэрээр нь ялгахгүй байна. KOICA/Солонгосын хамтын ажиллагааны байгууллага/-н тусламжаар баригдсан гараар хог ялгах цэгийг эс тооцвол хог хаягдлыг тэр чигээр нь байгальд хаяж

⁹Монголд сарын дундаж концентрацыг шалгуур үзүүлэлтийн хувьд тогтоогүй байдаг бөгөөд 24 цагийн болон жилийн дундаж үзүүлэлтийн хооронд буюу($50\sim 100\mu\text{g}/\text{m}^3$)-г жишиг болгодог. (JICA 2013)“Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чадавхийг бэхжүүлэх төслийн 2-р шат, Нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах судалгааны тайлан”)

¹⁰ С.Оюун (2016) “Улаанбаатар хотын агаарын бохирдол: өнөөгийн тулгарч буй аюул, ирээдүйн дүр зураг”

¹¹ ЖАЙКА “Монгол Улс, Улаанбаатар хотын ус хангамж, цэвэрлэх байгууламжийг сайжруулах төлөвлөгөөг боловсруулах судалгаа, Нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах судалгааны тайлан”

¹² ADB (2013) Asian Water Development Outlook 2013

байгаа бөгөөд энэ нь хур бороонд норж илжрэх, орчныг бохирдуулах, хүчтэй салхиар тарж хог болох, хур борооны усанд норж задран хөрсийг усыг бохирдуулах зэргээр сөрөг нөлөө үзүүлсээр байна.

2-4-3 Үйл явцын зохистой байдал

Бодлогын хэрэгжилтийг хангах үйл явцын зохистой байдал нь хэрэгжүүлвэл зохих арга хэмжээ болон тодорхой арга замууд нь монголын талын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохистойгоор хэрэгжиж, Монгол улс болон хандивлагч нараас үнэлэгдэж байгаа тул “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэгдэж, бодлогын хэрэгжилтийг хянах үйл явцын зохистой байдал нь монголын талын хэрэгцээ шаардлагыг тодруулан магадлаж, төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлэн, хандивлагч нар болон японы дотоодын үйл ажиллагаатай уялдаа холбоотой, зохицуулалттай байгаа нь зүй зохистой байгаагийн хажуугаар үр өгөөжтэй байдал болон мониторинг, үнэлгээний зарим хэсэгт шийдвэрлэвэл зохих асуудал байгаагаас “ерөнхийдөө өндөр”. Гэхдээ, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээлтийн зохистой байдлын тухайд зөвхөн байгаль орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаатай холбоотой жишээ цөөн, мөн байгаль орчны бохирдлын эсрэг хамтын ажиллагааны бодлого нь нэг баримт бичигт нэгтгэгдээгүйн улмаас Монгол Улсын ЗГ болон бусад тусламж, дэмжлэгийн байгууллага төдийгүй японы дотоодын тусламж, дэмжлэгийн холбогдох талуудад ч хангалттай ойлголт өгч чадаж байгаа гэж үзэхэд хангалтгүй. Иймд, үйл явцын зохистой байдлыг “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж байна.

(1) Бодлого хэрэгжүүлэх үйл явцын зохистой байдал

Байгаль орчны бохирдлыг бууруулахад Японы зүгээс үзүүлэх хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ болон тодорхой ажлууд нь монголын талын хэрэгцээ шаардлагад нийцэж, зохистойгоор хэрэгжиж буй бөгөөд энэ нь Монгол болон бусад хандивлагч нараас үнэлэгдэж байгаа бөгөөд бодлого хэрэгжүүлэх үйл явцын зохистой байдлыг “ерөнхийдөө өндөр” гэж дүгнэж байна.

Байгаль орчны бохирдлыг бууруулахад Японы зүгээс үзүүлэх хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ болон тодорхой ажлууд нь “Байгаль орчны бохирдлыг бууруулах чадавхийг сайжруулах”, “Иж бүрэн бөгөөд нэгдсэн байдлаар авч хэрэгжүүлэх хамтын ажиллагаа”, “Японы туршлага, шинжлэх ухаан, технологийг /харьцангуй тэргүүлэх/ ололтыг ашиглах нь”, “Байгаль орчны элементийг идэвхтэйгээр тусган багтаах арга хэмжээ”, “Японы манлайлан тэргүүлэх үйл ажиллагаа” гэсэн таван хэсгээс бүрдэнэ.

Япон нь Монголын хэрэгцээ шаардлага болон тэргүүлэх чанартай шийдвэрлэвэл зохих асуудалд төвлөрөн хамтын ажиллагааг хэрэгжүүлж, агаарын бохирдол, хог хаягдлын менежментийн салбарыг голлон дээрх 5 үйл ажиллагаанд анхаарч ирлээ. Монголын ЗГ-ын зүгээс “Байгаль орчны бохирдлыг бууруулах чадавхийг сайжруулах” хүрээнд агаарын бохирдол, хог хаягдлын менежментийн салбарын төрийн захиргааны хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үнэлж, “Иж бүрэн бөгөөд нэгдсэн

байдлаар авч хэрэгжүүлэх хамтын ажиллагаа"-ны хүрээнд хог хаягдлын менежментийн салбарын мастер төлөвлөгөөг боловсруулахаас авахуулаад санхүүгийн тусламж, технологийн хамтын ажиллагаа гэсэн нэгэн багц хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн нь үнэлэгдсэн билээ. Мөн, агаарын бохирдлын салбарын хувьд хувийн хэвшлийнхэний, хог хаягдлын менежментийн болон усны бохирдлын салбарын хувьд японы орон нутгийн засаг захиргааны байгууллагын мэдлэг, туршлагыг нэвтрүүлж ашигласнаар "Японы туршлага, шинжлэх ухаан, технологийг /харьцангуй тэргүүлэх/ ололтыг ашиглах нь" бодит биеллээ олсон. Азийн хөгжлийн банкны зүгээс, Улаанбаатар хотын хот байгуулалтын мастер төлөвлөгөөг боловсруулахад Япон манлайлан оролцсоноор дэд бүтэц, усан хангамж, байгаль орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллын ядуурлыг бууруулах зэрэг хамтын ажиллагаануудыг хэрэгжүүлж, "Байгаль орчны элементийг идэвхтэйгээр тусган багтаах арга хэмжээ"-нд хувь нэмрээ оруулсан гэж үнэлж байгаа юм. Япон, Монголын байгаль орчны бодлогын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж "Японы манлайлан тэргүүлэх үйл ажиллагаа"-г хэрэгжүүлэн ажиллаж байгааг цохон дурьдаж болно.

(2) Бодлогын хэрэгжилтийг хянах үйл явцын зохистой байдал

Монголын талын эрэлт хэрэгцээ болон бусад хандивлагч орнуудын мэдээллийг зохих хэмжээнд зөв тодорхойлж, байгаль орчны бохирдлыг шийдвэрлэх хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. Нөгөө талаар үр өгөөж талаас авч үзвэл Монголын талд Засгийн газар солигдон хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн хийгдэж, төсөв хүндрэлд орох зэрэг асуудал, Японы талд төсөл хэрэгжүүлэх процесст олон процедур, цаг хугацаа шаардагдах зэрэг асуудал гарч буйг холбогдох хүмүүс онцлон тэмдэглэж байв. Дотоодын холбогдох байгууллагууд, бусад хандивлагчидтай бодлого, арга хэмжээгээ тохируулж, хамтран ажиллахдаа хязгаарлагдмал тусламжийн хөрөнгийг үр дүнтэй, өгөөжтэй ашиглаж ирсэн гэж үнэлж болно. Байгаль орчны бохирдлыг хэрхэн шийдвэрлэж буй талаар өргөн хүрээнд мониторинг үнэлгээ хийгддэггүй. Гэхдээ төслийн хүрээнд зохих хэмжээнд мониторинг үнэлгээ хийгддэг тул бодлогын хэрэгжилт, удирдлагын процессийн зохистой байдлыг "ерөнхийдөө өндөр" гэж дүгнэж байна.

(3) Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх арга хэмжээний зохистой байдал

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх арга хэмжээг авч үзвэл олон улсын хэмжээнд болон тусламж хэрэгжүүлж буй орон, Японы дотоодод төслийн хүрээнд мэдээлэл түгээж буй хэдий ч байгаль орчны бохирдлын мэдээллийг ил тод болгох, олон нийтэд түгээх тал дээр боломж бага байна. Мөн байгаль орчны хамтын ажиллагааны бодлогыг товч нэг өгүүлбэрээр бичдэг тул Монгол улсын Засгийн газар, бусад хандивлагч байгууллага төдийгүй Япон дотроо холбогдох хүмүүсийн хооронд ч сайтар ойлголттой болсон гэж хэлэхэд хүндрэлтэй байна.

2-4-4 Гадаад бодлогын өнцгөөс үнэлэх нь

Байгаль орчны бохирдлыг шийдвэрлэхээр Японоос Монголд хэрэгжүүлж буй хамтын

ажиллагааны бодлогод гадаад бодлогын ач холбогдол, дагавар үр нөлөө гэсэн 2 үзүүлэлтээр үнэлгээ хийсэн. “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр” батлагдаж, хоёр орны найрсаг харилцаа, харилцан итгэлцэл улам бэхжин, байгаль орчны бохирдлыг бууруулах бодлого нь Монголын ард түмний эрүүл мэнд, нийгмийн халамжийг дээшлүүлэхэд чухал хамтын ажиллагаа хэрэгжиж ирсэн гэж үзэж болно.

Мөн байгаль орчны бохирдлыг бууруулах бодлогоор дамжуулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах нь Монголд хувийн хэвшлийн компаниуд бизнес эрхлэхэд гарах эрсдлийг бууруулахад хувь нэмэр оруулсан гэж дүгнэж байна. Хоёр орны байгаль орчны хамтын ажиллагаанд Японы “Хамтарсан кредит олгох механизм” (JCM)-ыг хэрэгжүүлсэн анхны орон нь Монгол улс юм. Энэ туршлага нь Япон болон бусад Азийн орнуудтай JCM байгуулахад эерэг нөлөө үзүүлсэн гэж үзэж болно. Бодит байдалд өнөөг хүртэл Японы хувийн хэвшлийн компаниудын оролцоотой JCM-ын 5 төсөл сонгогдоод байна. Мөн ЖАЙКА болон Европын сэргээн босголтын банкны хамтын санхүүжилтээр Японы хувийн хэвшлийн компаниуд байгаль орчны хамааралтай төсөл хэрэгжүүлэхээр болоод байна. Ийнхүү Японы байгаль орчны бохирдлыг шийдвэрлэхээр Монголд хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа нь Япон, Монголын дипломат, найрсаг харилцаа төдийгүй Азийн бүс нутаг дахь хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан гэж үнэлж болно.

3-р бүлэг. Монгол улсын байгаль орчны бохирдлыг бууруулах бодлогыг сайжруулах талаарх зөвлөмж

Үнэлгээний дүнд тулгуурлан Монгол улсын Засгийн газарт хандан байгаль орчны бодлогыг сайжруулах зөвлөмжийг нэгтгэж боловсруулна. Монгол улсын Засгийн газар дараах арга хэмжээг аль болох эрт хэрэгжүүлвэл зохистой бөгөөд Япон улс үүнд дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.

3-1-1 Бусад салбарын ХАЁТ-ийг хамруулсан өргөн хүрээний зөвлөмж

【Зөвлөмж 1】 Байгаль хамгаалах хандлага

Монгол улсад эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах асуудал нэн тэргүүнд тавигдан, байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ төдийлөн урагшилж чадахгүй байгаа тул Монгол улсад байгаль орчны хамгаалах асуудлыг гол хандлага болгох шаардлагатай. Түүнд авах арга хэмжээ нь 1) Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн эдийн засгийн үйл ажиллагааг явуулахад ч байгаль орчны асуудлыг харгалзсан элементийг түлхүү оруулах, 2) Монгол улсын яам, тамгын газруудын боловсруулсан салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар Ерөнхий сайдын удирдлага дор бодлого, төлөвлөлтийг яам, тамгын газар хооронд зохицуулалт хийх эрх мэдэлтэй зөвлөлийг нэн даруй байгуулах нь зүйтэй.

(Үндэслэл болон асуудал)

- Монгол улсад сүүлийн жилүүдэд байгаль орчны бохирдол хурцадмал байдалтай байгаа нь улс төрч, мэргэжилтэн, албан хаагч, ард иргэд өргөн хүрээнд ойлгож байгаа хэдий ч эдийн засгийн хүндрэлийг даван туулах асуудал нэн тэргүүнд тавигдан байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ төдийлөн урагшлахгүй байна.
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 болон байгаль орчны салбарын бодлогоос харагдаж байгаачлан шинэ Засгийн газар байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээг тусгасан бодлого хэрэгжүүлэхээр баталсан хэдий ч төсвийн хуваарилалт хийх эрх мэдэл бүхий УИХ-ын гишүүдийн байгаль орчны талаар ухамсар харилцан адилгүй. Ихэнх УИХ-ын гишүүд өөрийн бизнесийн компанитай түүнчлэн ХАА-н үйлдвэрлэгчдийн эрх ашгийг төлөөлөн, богино хугацаанд ашиг орлогоо нэмэгдүүлэх сонирхолтой нь үүнтэй холбоотой гэж үзэж байна.
- ХАА, эдийн засгийн хөгжил, эрчим хүч, зам тээвэр зэрэг салбарын бүх яам болон түүний харъяа агентлаг болон тус тусын хэрэгжүүлэх төслийн төсөв бүрдүүлэлт, хэрэгжилтэд хамгийн их ач холбогдол өгдөг.

【Зөвлөмж 2】 Бодлогын үнэлгээний тухай хууль боловсруулах, үндэсний үнэлгээний бодлого нэвтрүүлэх, үнэлгээ хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх

Япон улсын өмнөх туршлагаас санаа аван, Монгол улсын бодлого төлөвлөлтийн үнэлгээний тухай хуулийг боловсруулан, үндэсний үнэлгээний бодлого нэвтрүүлэх, үнэлгээ хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх замаар хөгжлийн болон байгаль орчны 2 талаас авах арга хэмжээг Монгол улс өөрсдөө үнэлэх механизмыг бүрдүүлэх шаардлагатай.

(Үндэслэл болон асуудал)

- Аливаа улс оронд “хөгжил, байгаль орчин, үнэлгээ” гэсэн 3 асуудлыг хуульчлах хэрэгцээтэй байдаг. Япон улсад 1960 аад оны сүүлээр орчны бохирдлын асуудлаар парламент хуралдаж, орчны бохирдлын тухай хууль, тогтолцоо бүрдүүлэн, 2001 онд бодлогын үнэлгээний боловсруулагдан бүх яамд, агентлаг дээр дотоодын болон гадны үнэлгээний хороо байгуулагдсан.
- Монгол улсын хувьд бодлогын үнэлгээний тухай хууль, үндэсний үнэлгээний тухай бодлого боловсруулах, хэрэгцээтэй тогтолцоо бүрдүүлэх талаар хараахан яригдаагүй байгаа. Байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ болон хамтын ажиллагааны үр дүн байгаль орчныг хамгаалах үйлсэд бодитоор хувь нэмэр оруулахад “бодлого, хууль, эрх зүйн тогтолцоо” гэсэн 3 үндсэн элемент байх хэрэгтэй бөгөөд Монгол улс өөрсдийн хөгжлийн болон байгаль орчны аль аль талаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлэх механизмыг бэхжүүлэх хэрэгтэй.

【Зөвлөмж 3】 Улаанбаатар хотын байгаль орчны эсрэг арга хэмжээнд нөлөөлөх бусад бодлого

Хүйтний улирлын агаарын бохирдлын гол шалтгаан болох гэр хорооллын нүүрсний

зуухны талаар бодлого, жилийн туршид агаарын бохирдлын шалтгаан болох автомашин болон дизель түлшний автомашинд авах арга хэмжээ, замын түгжрэлийн эсрэг авах арга хэмжээ зэрэг тус бүрийн талаар Монголын тал болон Япон, бусад хандивлагчид хамтран авч хэлэлцэж байна.

1) Гэр хорооллын нүүрсний зууханд авах арга хэмжээ

Богино хугацаанд, зуухнаас ялгарах CO₂ багасгасан сайжруулсан зуух, цэвэршүүлсэн нүүрсийг дэлгэрүүлэхийн тулд аж үйлдвэрийн салбарт хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих зэрэг ард иргэдэд зориулсан санхүүгийн механизм, сайжруулсан зуухыг бага үнээр түрээслэх тогтолцоог нэвтрүүлэх хэрэгтэй. Дунд хугацаанд гэр хорооллын цахилгаан болон халуун усны хангамжид зайлшгүй шаардлагатай дэд бүтцийг сайжруулах болон төлбөрөө бага багаар төлөх тогтолцоог үе шатлалтай хэрэгжүүлэх, түүний эхний арга зам болгон Улаанбаатар хотын хуучин, шинэ орон сууцанд амьдрах дунд болон өндөр орлоготой иргэдээс бүтнээр нь төлбөр авах зэрэг тогтолцоог яаралтай нэвтрүүлэх хэрэгтэй.

2) Суудлын автомашины болон дизель автомашинд авах арга хэмжээ

Богино хугацаанд түлшний ашигт үйлийн коэффициентийг сайжруулан, цахилгаан автомашин, гибрид автомашины хэрэглээг дэмжих зээл, татварын бодлогоор дэмжих ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай. Үүний зэрэгцээ Сингапурын туршлагаар оргил цагаар аль болох нэг нэгэндээ дайгдах тогтолцоог нэвтрүүлэн, торгуулийн системийг чангатгах нь зайлшгүй шаардлагатай. Дунд хугацаанд мөн Сингапур шиг шинэ автомашины бүртгэлийг хязгаарлах тогтолцоог нэвтрүүлэн, хэрэгжилтийг чандлан мөрдөх хэрэгтэй.

3) Автозамын түгжрэлд авах арга хэмжээ

Өнөөгийн хот суурин газрыг дахин хөгжүүлэх төлөвлөгөөг сайжруулахад Австралийн Канберра хотын туршлагаар сургууль, эмнэлэг зэрэг олон нийтийн газар болон худалдааны хорооллын нэгтгэсэн хорооллыг дахин төлөвлөх, аж үйлдвэрийн бүсийг хотоос зайдуу тараан байрлуулах зорилготой газар дахин зохион байгуулалт, Токио зэрэг томоохон хотуудад байдагчлан тойрог автозамыг олноор барих ажил яаралтай шаардагдаж байна. Богино хугацаанд Улаанбаатар хотын ИТХ-ын газар дахин зохион байгуулах төслөөр орон сууц болон нийтийн үйлчилгээний барилгыг шинээр барихыг хориглох, хязгаарлах, хотын нийтийн тээврийн автобусны хэт олшролт, маршрутын давхцалаас үүдсэн замын түгжрэлийг шат дараалан шийдвэрлэх шаардлагатай. Нөгөөтэйгүүр хот суурин газрыг дахин хөгжүүлэх төлөвлөгөө болон автозамын сүлжээг дахин зохион байгуулахын тулд санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас харгалзан дунд хугацааны төлөвлөгөө болгон зорилтот оныг тодорхойлох шаардлагатай.

(Үндэслэл болон асуудал)

• Улаанбаатар хотод хүйтний улирлын агаарын бохирдлын эх үүсвэр нь гэр хорооллын чанар муутай нүүрснээс шалтгаалсан дутуу шаталттай зуух байдаг ба гэр хороололд шилжин суух иргэдийн хязгаарлах нь Үндсэн хуулинд заагдсан эрх чөлөөг

хөсөрдүүлэх тул боломжгүй байх магадлалтай. Жилийн туршид агаарын бохирдлын гол шалтгаан нь жил бүр өсөн нэмэгдэх автомашин болон дизель машин юм. Түүнчлэн агаарын бохирдлын бас нэг шалтгаан бол нийслэл хот руу шилжин суурьших хүн амын өсөлт, суудлын автомашины өсөлт, нийтийн тээврийн хэрэгслийн хүрэлцээгүй байдал зэрэг замын түгжрэл юм.

【Зөвлөмж 4】 Орон нутагт тогтвортой ХАА-г сэргээн босгох

Монгол улсын хувьд тогтвортой ХАА-г сэргээн босгож, хөгжүүлэх шаардлагатай. Монгол улсад дараа дараагийн удаад үзүүлэх тусламж, дэмжлэгийн бодлогод дэмжлэгийг орон нутагт ч мөн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ, орон нутаг дахь гол үйлдвэрлэл болох ХАА голлосон бусад бусад салбарыг хамруулсан байхаар авч үзэх боломжтой. Тухайлбал, ихээхэн хэмжээний ойжуулалтаар ой модыг нөхөн сэргээх, усны эх үүсвэрийг хамгаалах, органик ХАА-г хөгжүүлэх, хүнсний ногоо болон жимс жимсгэний тариаланг нэмэгдүүлснээр газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, мөн дунд болон урт хугацаанд өргөн уудам газарт тархан суурьшдаг малчдад зориулж нар, салхины цахилгаан эх үүсвэр, бага оврын усан цахилгааны үүсвэр зэргийг нэвтрүүлснээр ахуйн бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, бэлчээр нутагт ч нэмэгдэж буй хатуу хог хаягдлыг байгаль орчинд ээлтэйгээр боловсруулах зэрэг арга зам байж болно.

(Үндэслэл болон тулгамдаж буй асуудлууд)

- Монголын уламжлалт үйлдвэрлэл болох МАА эрхлэн аж төрөх малчид нь зах зээлийн эдийн засагт шилжсэнээр Улаанбаатар болон Дархан зэрэг ойролцоо хотууд руу шилжин суурьших зэргээр маш их цөөрч байна. Түүнчлэн хотжилтоос үүдэн агаар, усны бохирдол, ой модны сүйтгэл нь бэлчээрт хохирол учруулж байна. Мөн цөлжилт нутгийн хойд хэсэг рүү түрэн орж ирж буйгаас газрын доройтол нэмэгдэж буй нь дунд болон урт хугацаанд малчдад аюул занал болж байна. Энэхүү байдал болон мөн ойрын ирээдүйд үүсч болзошгүй байгаль орчны доройтолд урьдчилан бэлтгэх арга хэмжээ авах шаардлагатай.

3-1-2 Байгаль орчны салбар дахь ХАЁТ-ийн талаарх санал

【Зөвлөмж 5】 Байгаль орчинтой холбоотой бодлого болон төрийн бодлогын хувьд байгаль орчны асуудлыг анхаарах, бодлогод тусгах асуудлыг дэмжих үүднээс хүний нөөцийг хөгжүүлэх

Монгол улсын тухайд байгаль орчны асуудлыг бодлогод тусгахыг дэмжин, орчны бохирдлын байдлыг сайжруулахын тулд байгаль орчинтой холбоотой болон төрийн бодлогын тухайд байгаль орчны асуудлуудыг чухалчлан авч үзэж явах хүний нөөцийг бэлтгэх нь урьдын адил шаардлагатай хэвээр байна. Байгаль орчныг хамгаалах асуудлыг бодлогод тусгахад байгаль орчноос бусад салбарыг хамруулсан төрөл бүрийн арга хэмжээ хэрэгтэй ба байгаль орчны асуудлыг чухалчлан үзэж, бодлогод тусгахыг дэмжих боловсон хүчнийг бэлтгэх нь бодлогод тусгахыг хэрэгжүүлэхийн тулд

бодит арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дэмжих, түүний хэрэгжилтийн түвшин дэхь тасралтгүй үйл ажиллагааг хангах зэрэг байгаль орчин хамгаалах асуудлыг бодлогод тусган хэрэгжүүлэхэд туйлын чухал ач холбогдолтой юм.

Бодитоор хэрэгжүүлж болох арга хэмжээ нь ерөнхий боловсролын дунд сургуулиудад экологийн боловсрол олгох сургалт, дадлагын тогтолцоо, ажлын байран дахь сургалт, их дээд сургуулийн судалгаа шинжилгээ, гадаад улс дахь сургалт, гадаадаас мэргэжилтэн урьж, судалгаа, сургалт явуулан мэргэжлийн салбарын сургалт болон сургалтын чанарыг сайжруулахаар сургалтын материал бэлтгэх, сургалтын арга зүй, сургалтын орчин болон хүрэлцээ хангамжийг сайжруулах, бэлтгэсэн хүний нөөцийн ашиглалт, томилгоог сайжруулах, ажил мэргэжилд ахиж дэвших төлөвлөгөөг нэвтрүүлэх зэрэг байж болно. Мөн бэлтгэсэн хүний нөөц нь Монголын талын засгийн эрх болон албан тушаалтнуудын өөрчлөлттэй холбоотойгоор байнга солигдож, сул орон тоо гарах зэргийн тухайд Монгол талын зохих арга хэмжээ ч шаардлагатай болохыг анхаарууштай. Судалж үзвэл зохих арга хэмжээ нь (1) Өнөөг хүртэл сургалтанд хамрагдсан хүний нөөцийн мэдээллийн санг бий болгох, дутагдаж буй салбарын хүний нөөцийг бэлтгэх төлөвлөгөөг боловсруулах зэрэг болно. Гэвч мэдээллийн сан бий болгох нь тусламж авч буй улсын хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөөс шалтгаалан бодит хэрэгжилтийн байдал болон үр дүнгийн хувьд ихээхэн ялгаа гарах магадлалтай бөгөөд ярилцаж, хэлэлцэн Монгол улсын нөхцөл байдалд тохирсон бэлтгэсэн хүний нөөцийг удирдах арга замын талаар судалж үзэх хэрэгтэй гэж үзэж байна.

(Үндэслэл болон тулгамдаж буй асуудлууд)

• Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Японы Монгол улсад үзүүлэх ХАЁТ-ийг оролцуулан байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц бэлтгэх болон тогтолцоо бий бүрдүүлэхэд анхаарч ирсэн боловч улам бүр нэмэгдэх ажлын ачааллыг хүний нөөцийн бэлтгэл нь гүйцэхгүй, үргэлж хүний нөөц дутагдалтай байсаар байна. 2000 оноос хойш Монголын Засгийн газрын эдийн засгийг сэргээх, өсөлтийг хангах тэргүүлэх бодлогод хэрэгжүүлэхэд ч Монголын засгийн эрх солигдох болон удирдах албан тушаалтнуудын өөрчлөлтөөс болоод албан хаагчид байнга солигдон орон тоо дутагдах асуудал ч гарна. Агаар, усны бохирдол, газрын доройтол, хатуу хог хаягдлын эрс нэмэгдэл зэрэг байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээ, биологийн олон төрөл зүйлийг хамарсан байгаль хамгаалах бодлогыг боловсруулах хэрэгжүүлэх, аливаа төрийн бодлогын боловсруулалт, хэрэгжүүлэлтэд байгаль орчныг чухалчлан авч үзэж, бодлогод тусгах хүний нөөц болон холбогдох хууль тогтоох, засаглах, шүүхийн чадавхи, тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай хүний нөөц хүрэлцээгүй байна.

【 Зөвлөмж 6 】 Байгаль орчны холбогдолтой мэдээлэл цуглуулах, дүгнэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх

Монгол улсын байгаль орчин хамгаалах салбар дахь үр өгөөжтэй үр дүнг (үр дүн, үр

нөлөө) хангахын тулд өргөн цар хүрээтэй холбогдох мэдээллийн үнэн бодит, түргэн шуурхай бөгөөд тогтмол ажиглалт бүхий мэдээллийн тогтмол цуглуулалт болон мэдээллийн анализ, хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхи, тогтолцоог нэвтрүүлэх, бүтэц зохион байгуулалт бий болгох нь нэн тэргүүний ажил болно. Тухайлбал, ерөнхий боловсролын дунд сургууль дахь сургалтын систем, ажлын байран дахь сургалт, их дээд сургуулийн судалгаа шинжилгээ, гадаад улс дахь сургалт, гадаадаас мэргэжилтэн урьж, судалгаа, сургалт явуулан мэргэжлийн салбарын сургалт болон сургалтын чанарыг сайжруулахаар сургалтын материал бэлтгэх, сургалтын арга зүй, сургалтын орчин болон хүрэлцээ хангамжийг сайжруулах, бэлтгэсэн хүний нөөцийн ашиглалт, томилгоог сайжруулах, ажил мэргэжилд ахиж дэвших төлөвлөгөөг нэвтрүүлэх зэрэг байж болно.

(Үндэслэл болон тулгамдсан асуудлууд)

- Монгол улсын агаарын бохирдлын мэдээлэл цуглуулах тухайд Улаанбаатар хот болон ойролцоох хотуудын хувьд мониторингийн чадавхи дээшилж буй нь харагдах ч орон нутаг дахь мониторинг хангалтгүй байна. Усны бохирдол, хөрсний бохирдол, хатуу хог хаягдлын бодит хэмжилт нь бүхэлдээ хангалтгүй байдалтай байна. Агаарын бохирдлын талаарх мэдээллийн дүн шинжилгээ, үнэлгээний тухайд ч тусламж, дэмжлэг шаардлагатай үе шатанд байна.

【Зөвлөмж 7】Олон төрлийн оролцогч талуудын байгаль орчин хамгаалах оролцооны бүтцийг бий болгох

Монгол улсын байгаль орчны бохирдлын эсрэг бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, мониторинг, үнэлгээний аливаа үе шатанд орон нутаг, хувийн хэвшил, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн оролцогч талууд оролцох хэрэгтэй.

(Үндэслэл болон тулгамдсан асуудлууд)

- Монгол улсад хүн амын хэт их шилжин суурьшилтаас үүдэн Улаанбаатар хот орчны бохирдол газар авч байгаа учраас хотын захиргаа Засгийн газрын бодлогод нийцүүлэн хотын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, идэвхтэй бөгөөд бодитойгоор Улаанбаатар хотын орчны бохирдлыг бууруулахаар ажиллаж буй гэж үнэлэгдэж байгаа.
- Нөгөөтэйгүүр, агаарын бохирдлын талаар техникийн хамтын ажиллагааны төсөл ч Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа байгууллага болох NAMEM-аар дамжуулан Улаанбаатар хот болон Байгаль орчны яаманд бодлогын зөвлөмжийг хүргүүлсээр ирсэн боловч зарим үед Улаанбаатар хот болон Засгийн газрын уялдаа холбоо сул байдлаас шалтгаалан зөвлөмж болон тогтолцооны хэрэгжилт нь хангагдахгүй тохиолдол байдаг. Эцсийн байдлаар байгаль орчны бохирдлын бодлого хэрэгжүүлэх нь байгаль орчны бохирдлын нөлөөлөлд шууд өртөж буй орон нутаг бөгөөд орон нутгийн захиргаа бодитойгоор ашиглан, сайжруулах бүтцийг бий болгох нь чухал.
- Байгаль орчны бохирдлын хохирлын нөлөөллөлд өртөх нь иргэд бөгөөд бүр ихээр

өртөх нь нийгмийн эмзэг давхаргынхан юм. Монгол улсад хотын төвийн элитүүд нь улстөрч болох нь их бөгөөд хотын захын гэр хорооллын нийгмийн эмзэг давхаргын иргэдийн байр суурийг бүрэн дүүрэн ойлгодоггүй бөгөөд бодлогод тусгагддаггүй байна.

【Зөвлөмж 8】 Байгаль орчин хамгаалахтай холбоотой хууль эрх зүй болон удирдамж боловсруулах

Монгол улсын хувьд тогтсон хөрөнгө оруулалтын хэмжээ байхгүй бөгөөд газар болон барилгын хэмжээнээс илүү барилгад байгаль орчны үнэлгээ заавал хийх эрх зүйг бүрдүүлэн, байгаль орчны бохирдлын үүсвэр болох магадлалтай барилга байгууламж, үйлдвэр аж ахуйн нэгжид удирдамж нэвтрүүлэх, түүнийг сахин биелүүлэх үүрэг хүлээлгэх ажлыг яаралтай хэрэгжүүлэх хэрэгтэй

(Үндэслэл болон тулгамдсан асуудлууд)

- Байгаль орчны бохирдлын эх үүсвэр болох ДЦС, ус, хөрсний бохирдол, нийтийн эрүүл мэндэд муу нөлөө үзүүлэх цэвэрлэх байгууламж, чанар муу нүүрсээр галладаг халуун ус болон дулааны зориулалттай бага оврын уурын зуух ашигладаг сургууль, эмнэлэг, орон сууц, иргэдийн амьдрах орчинд муу нөлөө үзүүлэх хатуу хог хаягдлын булаах, шатаах байгууламж, тогтсон стандарт хэмжээнээс хэтэрсэн дуу чимээ, үнэр, доргилт үүсгэдэг үйлдвэр, аж ахуйн нэгжийн барилга байгууламжид хатуу чанд мөрдөх удирдамж байхгүй.

【Зөвлөмж 9】 Иргэдийн байгаль орчны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх

Байгаль орчны хамгаалахтай холбоотой хууль эрх зүйн тогтолцоо болон удирдамж боловсруулах (зөвлөмж 7), Улаанбаатар хотын байгаль орчны бохирдлын бодлогод тусгах төрөл бүрийн арга замыг судлах, хэрэгжүүлэх (зөвлөмж 8) дээр нэмэн бүх ард иргэдийн байгальд орчны талаарх ойлголтыг нэмэгдүүлснээр нийт улсын хэмжээнд тогтвортойгоор байгаль орчны бохирдлын нөхцөл байдлыг сайжруулах болно. Тийм учраас иргэдийн байгаль орчны талаарх боловсролыг сайжруулахын зэрэгцээ иргэдийн байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх бодит үйл ажиллагаа явуулахын тулд хувийн хэвшил болон Засгийн газрын хамтын ажиллагааны үндэс Японы Дэлхийн байгаль орчны сангийн адил байгаль орчны төрийн бус байгууллагыг бий болгох нь нэг санал юм.

(Үндэслэл болон тулгамдсан асуудлууд)

- Байгаль орчинтой холбоотой бодлого болон хууль эрх зүйн тогтолцоо үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд иргэдийн байгаль орчны талаарх мэдлэг мэдлэгийг нэмэгдүүлж, байгаль орчны бохирдлын эх үүсвэрийг багасгах, болон байгаль орчин хамгаалахад тус нэмэр болох үйл ажиллагааг дэмжих нь зайлшгүй чухал.
- ЕБС дахь агаарын бохирдлыг талаарх сургалт болон байгаль орчны төрийн бус байгууллагын хог хаягдлын ангилалын талаарх үйл ажиллагаа зэрэг иргэдэд чиглэсэн байгал орчны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд тус болох хэд хэдэн үйл

ажиллагаа байх бөгөөд Монголын бүх яам газруудад хэлж байсанчлан иргэдийн байгаль орчны талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дээр дурьдсанчлан олон асуудлыг шийдвэрлэхэд Япон улсын Монгол улсад үзүүлэх тусламж нь цаашид хот, хөдөө аж ахуйн эдэлбэр газар алинд ч байгаль орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээг улам боловсронгуй болгох ажлыг нэн даруй хэрэгжүүлэх хэрэгтэй. Гэхдээ дан ганц Япон улсын тусламжаар Монгол улсад тулгамдаж буй эдгээр өргөн хүрээтэй хурцдаж буй агаарын бохирдол, усны бохирдол, газрын доройтол, цөлжилт, хатуу хог хаягдлыг боловсруулах асуудлуудыг шийдвэрлэх нь хүндрэлтэй бөгөөд цаашид олон улсын хамтын нийгэмлэгтэй хамтарсан тусламж, хэлэлцүүлэг, зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Монгол улсад үзүүлсэн ХАЁТ-ийн өнөөг хүртэлх 25 жилийн туршид хамгийн их тусламж үзүүлсэн орон болох Япон улс нь эдгээр байгаль орчны бохирдлын эсрэг арга хэмжээний тухайд ч удирдан чиглүүлж, Монгол улсын Засгийн газартай хэлэлцсэний үндсэн дээр олон улсын нийгэмлэгд санаачлага гарган, Монгол улсын тогтвортой хөгжлийн төлөө стратегийн түншийн үүргээ биелүүлэх нь хоёр орны ирээдүйн нягт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зам болох болов уу гэж үзэж байна.